## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГИЙН "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР" ХИЙСЭН 2024 ОНЫ ТАЙЛАНГИЙН БИЕЛЭЛТ

2024.11.25

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхижүүлэх | | | | | | |
| 1 | Засгийн газар, байгууллага, бусад байгуулллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1 | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо | | | |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | | 100 | ЭМДҮЗ-ийн шинэ тогтоолын сургалт эмч нарт 3 сургалт 172 хүнд дотоодын ажлын байран дахь дадлагажуулах сургалт хийгдсэн. e-Health программын чиглэлээр 8 сургалт, 86 хүн. • Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны "Мэргэжлийн чиглүүлэх сургалтын хөтөлбөр"-ийн дагуу нийт 5 удаа сургалтыг зохион байгуулж 89 шинэ ажилтанг хамруулсан. Сувилахуйн ажлын байрны ганцаарчилсан сургалт нийт 910 зохион байгуулсан байна. ● 2024 оны 09 дүгээр сараас эхлэн Долоо хоногт 2 удаа ЭМС-ын 2019 оны 11 сарын 29-ны өдрийн А/537 тоот заавар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/54 тоот тушаалын дагуу сургалт орсон. Давхардсан тоогоор 323. ● Uptodate платформд хэрхэн хандалт хийх чиглэлээр ЭМТҮЧАБАлбанаас эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт давтагдсан тоогоор 2 удаагийн нийт-120 буюу 100% хамрагдалттай.<br>● Унах эрсдэлийн үнэлгээг тогтмол сургалт хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Ганцаарчлан болон бүлгийн сургалт нийт 115 сувилагч хамрагдсан байна.<br>● Үйлчлүүлэгч зөв таних журам мөрдөөгүйгээс үүсэх эрсдэл нийт 3 бүртгэгдсэн. Үүнтэй холбоотой |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ганцаарчилсан сургалт, тохиолдлын хуралд сургалтыг 3 удаа 95 сувилагч, тусгай мэргэжилтэн хамруулж хийсэн.<br>● Нийт эмч, эмнэлгийн ажилтанд "Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах" сургалтыг зохион байгуулсан. Хамрагдалт 121.<br>● АУ доктор, Уб Сонгдо эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч зөвлөх эмч Н. Нарьяа Астма болон архаг уушгиний архаг ханиалга намдаах сэдвээр эмч нар сургалтыг 35 эмч, эмнэлгийн ажилчдад орсон.<br>● 2024 оны 09 дүгээр сарын 18ны өдөр ЭХЭМҮТ-ийн Чанарын албаны дарга, Хүүхдийн эрчимт эмчилгээний МУ-ын Хүний гавьяат эмч А. Оюунчимэг эмч "Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, амьсгалын дутагдалын менежмент" сэдвээр эмч эмнэлгийн мэргэжилтэнг чадавхжуулах сургалыг 49 ажилтад хийсэн.<br>● 2024 оны 10 дугаар сарын 03нд нд эмнэлгийн нийт ажилчдын дунд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын ДЭМБ-ын бодлого, ЭМТҮ-ний тохиолдол эрсдэл, алдаа сургамж сэдвээр ЭХЭМҮТ-ийн ЭМТҮЧАБАлбаны Хүүхдийн эрчимт эмчилгээний их эмч, МУ-ын Хүний гавьяат А. Оюунчимэг эмчээс Эмч мэргэжилтэн нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, ёс зүй харилцаа хандлагыг нэмэгдүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 111 ажилтан хамрагдсан.<br>● Даралтат савтай ажиллах 4 ажилтад аюулгүйн ажиллагаа болон ажиллах зааварчилгаа өгөх<br>● ЯТЭЭ-ний тасаг болон Био салбарын 15 ажилтанд амьсгалын аппарат, хяналтын монитор, дебифрилятор, өвчтөнг тээвэрлэх үед хүчилтөрөгчийн баллон болон, зөөврийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амьсгалын аппаратны аюулгүй ажиллагаа болон ажиллах үеийн зааварчилгаа өгөх<br>● Дотор мэдрэлийн тасагт хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дусал шахуурга, тарианы шахуурга аппаратанд тохиргоо хэрхэн хийх ажиллах үед гарах алдааны заавpыг өгөх<br>● Ханын хүчилтөрөгчийн хэрэглээ, хүчилтөрөгчийн бобров савны цэвэрлэгээ эвдрэл гэмтлийн талаарх гэсэн хөтөлбөрүүдийн дагуу нийт 8 удаагийн сургалт явуулсан.<br>Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалтыг нийт ажилчдад 6 удаа хийсэн. Хамрагдсан ажилтны тоо-186<br><br>• Сувилахуйн албаны яриа 10 удаа зохион байгууллаж ур чавдар мэдлэг дээшлүүлэх сургалт хийсэн.<br><br>Хавдарын хими эмчилгээгээр 1 эмчийг 6 сарын хугацаатай төрөлжсөн нарийн мэргэжлээр Химийн эм найруулагчаар эм хангамжийн тасгийн эрхлэгчийг 3 сарын хугацаатай сургаж хүний нөөцийн хангалтыг хийсэн. |
| | | | Мэргэшүүлэх сургалт | | 100% | УНТЭмнэлэгт тасаг нэгжүүдэд ажлын байранд дадлагажуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Хамрагдсан ажилтаны тоо 8.<br>- ЭХЭМҮТөвд Хүүхдийн эрчимт эмчилгээний чиглэлээр 4 их эмчийг хамруулах төлөвлөгөөтэй байна.<br>- Төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр ММЗаслын их эмч 1, Бөөрний диализийн их эмч 1, Хүүхдийн их эмч 2, Допплерографийн их эмч 1,ЭЭГ их эмч 1,Хүүхдийн зүрхний их эмч 1, Хавдарын химийн их эмч 1 тус тус сургаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Чанарын удирдлагын чиглэлээр 4 ажилтанг 5 хоногийн багц цагийн сургалтанд хамруулсан. Зарцуулсан төсөв 1120 мян төгрөг<br>- Дотоод аудиторын сургалтанд 4, А/3 худалдан авах ажиллагааны сургалтанд 10 ажилтан хамруулсан.<br>- Хүүхдийн зүрх судасны 1 эмчийг ЭХЭМҮТ ийн зүрхний мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан.<br>-Эрчимт эмчилгээний эмч нарыг дадлагажуулах, мэдлэг сэргээх зорилгоор ЭХЭМҮТ -ийн эрчимт эмчилгээний тасагт 2 эмчийг 1 сарын хугацаатай сургалтанд хамруулсан.<br>- Оросын холбооны улсын Сантпетербург хотод хүүхдийн яаралтай тусламж, хүүхдийн яаралтай тусламжийн 10 хоногийн вакумжуулсан сургалтанд 3 хүүхдийн эмчийг хамруулсан. Зарцуулсан төсөв 9.6 сая төгрөг.<br>- ТӨРӨЛЖСӨН НАРИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАНД<br>-Бөөр судлал Диализийн эмчээр Ч.Эрдэнэсувдыг 1,6 сарын сургалт,<br>-Р.Баасанцэрэн мэдрэлийн эмч “ доплер дуплекс “ чиглэлээр УГТЭ-т 6 сарын хугацаатай сургалт,<br>-Л.Алдармаа хавдарын эмч “ Хавдарын хими эмчилгээ “ чиглэлээр ХСҮТ-д 6 сарын хугацаатай сургалт,ЭМХТөв<br>УТГЭ – Б.Түвшинбаяр эмч мэдрэлийн мэс засал судлалаар.<br>-Б.Мөнхпүрэв, Б.Сумья эмч нар 2024.10сараас эхэлж ХСҮТ-д ходоод, гэдэсний хавдрын мэс заслаар<br>-Ж.Отгонбаяр АШУИС-МЯСЭ-т хэвлийн хөндийн дурангийн мэс засалд, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Т. Пүрэвбаяр эмч зүрх судасны мэс заслаар<br>-Амбулаторийн сувилагч Г.Анхцэцэг, Х.Золзаяа нарыг чихрийн шижингийн нарийн мэргэжлийн сувилагчийн сургалтад,<br>-Сувилагч Ц.Амаржаргал-Сэргээн засахуйн сувилахуйн 3 сарын сургалт<br>-Чих хамар хоолойн эмч Энхмарал- Чих хамар хоолойн мэс заслын эмчээр тус тус сурган бэлтгэж ур чадварыг дээшлүүлэн мэргэшүүлсэн. |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | | | УНТЭ, УГТЭ, ГССҮТөвтэй хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж эмнэлгийн тусламж үйлчилгээ, оношилгоо, хүний нөөцийг чадавхижуулах, сэлгэн ажиллах, шинэ техник технологи нэвтрүүлэх, туршлага судлах чиглэлээр хамтран ажилласан.<br>Хамрагдсан ажилтны тоо-30<br>Хөх кодтой холбоотой ТТАХНЭмнэлэгт туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулсан. Хамрагдсан ажилтаны тоо:21<br>Гэмтэл хагалгааны нэр төрөл 6, ерөнхий мэс засал 4, судасны мэс засал 4, мэдрэлийн мэс засал 5, нэмэгдүүлэн ажилласан.<br>Хүний нөөцийг ажлын байранд ММЗ-1 их эмч, Ерөнхий мэс заслаар-2, Судасны мэс заслаар-1, Гэмтлийн мэс заслаар 1, Мэдээгүйжүүлгээр-1 сувилагч-2 сургаж дадлагажуулсан.<br>Төрөлжсөн нарийн мэргэжлээр 9 ажилтан хамрагдсан.<br>Хамтын ажиллагаа, гэрээ санамж бичгийн тоо:3<br>Сургалтын тоо:9<br>Хамрагдах хүний тоо:59 |
| | | | Бусад | | | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо | | 87 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | | 81 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | | 6 | |
| | | | Удирдах албан тушаалтан | | - | |
| | | | Гүйцэтгэх албан тушаалтан | | - | |
| | | 1.3 | Сургалтад хамруулсан байдал. Нийт албан хаагчдад эзлэх хувь | 90-ээс дээш | 100% | |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | | 100% | Гадаадад ОХУ-д хүүхдийн яаралтай тусламжийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад эмч-3, Тайван улсад туршлага судлах, хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээнд 11 ажилтан, Казакстан улсад “Олон улсын магадлан итгэмжлэл”-ийн хурал 2 менежер хамрагдсан. Бүгд-15 ажилтан<br>Нийт төсөв-31,155,000 төгрөг |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо | | 16 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | | 12 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | | 2 | |
| | | | Удирдах албан тушаалтан | | 2 | |
| | | | Гүйцэтгэх албан тушаалтан | | | |
| | | | Гадаадад сургалтад хамруулсан байдал.Нийт албан | 20-иос дээш | 6% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хаагчдад эзлэх хувь | | | |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, чиглэлээр | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая, төг) | | 7,140,400.00 төгрөг | |
| | | 3.2 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | 12% | Өөр ажлын байранд сэлгэн болон албан тушаал өөрчлөн ажиллуулсан ажилтны тоо 57 |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | | | | |
| 4 | Цалин хөлс, шагнал, урамшуулалын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1 | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | | | -2024 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын батлагдсан төсөв 11,012,260,700 төгрөг<br><br>11 сарын 29-ны байдлаар 8,769,119,196.00 төгрөгийн цалин урамшуулал олгосон байна.<br>- Нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны ажлын бүтээмж, үр дүнг харгалзан үзэж, (KPI) мөнгөн урамшууллыг улирал тутам олгож байна. Үүнд:<br>024 оны I улиралд:<br>Нийт 220 ажилтанд 177,237,229 төгрөг<br>2024 оны II улиралд:<br>Нийт 240 ажилтанд 150,014,251 төгрөг<br>2024 оны III улиралд:<br>Нийт 229 ажилтанд 265,804,135 төгрөг<br>I,II,III улирлын нийт урамшуулалд 593,055,615 төгрөгийг олгосон байна<br><br>Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан Хөдөлмөрийн хүндэт медаль, ЭМЯ, НЭМГ болон ХУДЗДТГ-ын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шагналуудаар эмч нарыг шагнасан. Нийт төсөв 500,000 төгрөг |
| | | 4.2 | Нэгж албан хаагчид олгон хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | | | Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийн дагуу эмнэлгийн захирлын 2023 оны А/124 тушаалаар 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Ажилтнуудын нэг өдрийн хоолны хөнгөлөлтийг 12,500 төгрөг болгож нэмэгдүүлсэн. |
| 5 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1 | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80дээш | 100 | Ажилтны ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ширээ сандал номын шкаф, компьютер, принтер, эмнэлгийн цахим сүлжээнд бүрэн холбогдсон. Ажилтнуудаа 2024 онд улсын төсвөөр 50 компьютер, 20 принтер шинээр хангаж ажилласан. Төв эмнэлэг,Салбар амбулатори, Био салбар эмнэлгийн бүх тасаг нэгжид ажилтны амрах өрөөг бий болгон суудлын буйдан, ширээ, сандал, гал тогооны шкаф, ус шүүлтүүр, хөргөгч зэрэг хангалт хийсэн үйл ажиллагаа хэвийн ажиллаж байна. Нийт-10 өрөө<br>Нийт төсөв 8,000,000 төгрөг |
| 6 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) | 90-ээс дээш | 93.1Хувь | Эмч эмнэлгийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх үзлэгийг 3 үе шаттай зохион байгуулж 8 төрлийн үзлэг шинжилгээнд, 271 ажилтан буюу нийт ажилтнуудыг 93.1%-ыг хамруулснаас 20% нь үзлэг шинжилгээнд өөрчлөлттэй гарсан. Үзлэг тус бүрээр үзлэвэл:<br>Хиймэл оюун ухааны тусламжтай умайн хүзүүний хавдар илрүүлэх шинжилгээ-64<br>Эмэнд тэсвэржсэн бичил биетэн илрүүлэх хөөмийн арчдас -271<br>Ясны сийрэгжилт илрүүлэх аппаратын шинжилгээ-127<br>Биохими, цус ерөнхий, шээсний ерөнхий шинжилгээ- 271<br>Хэт авиа, рентген, зүрхний бичлэг-271,<br>Хөхний эхо- 63 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бамбайн эхо- 63 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тус тус хамруулсан.<br>Эмч, эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх зорилгоор тархвар судлалын заалтаар 4 төрлийн дархлаажуулалтанд хамруулсан. Үүнд:<br>В Гепатитын дархлаа тогтоцын шинжилгээгээр нэмэлт тун шаардлагатай байсан болон дархлаажуулалтанд хамрагдаагүй ажилтнуудыг 1-р тунд 131, 2-р тунд 57, 3-р тунд 53 ажилтанг тус тус хамруулсан<br>Тарваган тахал өвчний эсрэг дархлаажуулалтанд 11 ажилтанг<br>Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтанд 81 ажилтан<br>Улиралын томуугийн эсрэг эсрэг дархлаажуулалтанд 95 ажилтанг тус тус хамруулсан.<br>Дархлаажуулалтын төрөл:4<br>Хамрагдсан ажилтны тоо:428<br><br>Хамрагдсан хүний тоо:513<br>Илрүүлэлтийн хувь:20%<br>Эрүүлжүүлэлтийн хувь: 95% |
| | | 6.2 | Албан хаагчдын хамрагдалт | 90-ээс дээш | 61.2хувь | |
| | | | | | | -Эмнэлгийн даргын 2024 оны дугаар тушаалаар 2024.09.01-10.01 хүртэл хугацаанд нийт ажилтнуудын ажлын цагийг “НЭГ” цагаар хорогдуулан ажиллуулсан.<br>Салбар Амбулаторийн ховор мэргэжилтэн (дуран, дүрс оношилогоо), томуугийн үед ажиллах ажилтнуудад үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл цалин олгож байна.<br>Үүнд: илүү цаг 1.461.135.859, шөнө цаг 730.988.237, нийтээр амрах баяр ёслолын өдөр 62.764.327 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцууласан зардал | 7.1 | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | | Нийт 8,675,508,121 | -Худалдаа хөгжлийн банктай гэрээлэн ипотекийн 6 хувийн орон сууцны зээлийн шалгуур хангасан 20 ажилтныг 2024 оны байдлаар хамруулсан.<br>Мөн 3 ажилтан зээлийн материалын бүрдүүлэлт хийж тус зээлд хамрагдахаар хүлээгдэж байгаа болно.<br>Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийн дагуу эмнэлгийн захирлын тушаалаар 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ажилчдын автобусыг /суудлын тоо-25/ үнэ төлбөргүйгээр ажил эхлэх, тарах цагт тогтмол явуулж эхэлсэн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна.<br><br>-Нийт ажилтнуудын дунд “Орон байрны хангамж, амьдрах орчны тухай судалгааны дүнгээс харахад ажилтнуудын 52% нь өөрийн эзэмшлийн орон сууцгүй гэр хороололд амьдарч байна. Цаашид Нийт 100 хүртэлх ажилтныг орон сууцаар хангах төлөвлөгөөтэй ажиллаж байна. |

ХЯНАСАН:
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ П. УНДАРМАА

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР Ж.МӨНХЗАЯА